МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2026.10.15 № 01/6490

танай 2026.09.30 -ны № 67 -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.НАРАНБАЯР ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 67 тоот албан бичгээр ирүүлсэн төрийн албан хаагчдын цалин хөлсний бодлогын талаарх асуулттай танилцан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1.Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх хүрээнд 2026 онд салбарын яам болон үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан хамтын хэлэлцээрээр тохирсон хувь, хэмжээгээр буюу эрүүл мэндийн салбарын эмч, ажилтны үндсэн цалинг 30 хувиар, боловсролын салбарын багш, ажилтны үндсэн цалинг 50 хувиар, шинжлэх ухааны ажилтны үндсэн цалинг 15 хувиар тус тус нэмэгдүүлсэн.

Дээрх байдлаар төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлснээр эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээний нэн чухал салбаруудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж, ажил хаялтыг зогсоосон боловч нөгөө талдаа цалин хөлс нь нэмэгдээгүй соёл, спорт, цаг уур, орчны шинжилгээ, стандарт хэмжил зүй зэрэг төрийн мэргэжлийн үйлчилгээний болон жолооч, манаач, цахилгаанчин зэрэг төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид, цэрэг, цагдаагийн төрийн тусгай албан хаагчид, төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын цалингийн хэт зөрүү үүсэж, цалин хөлсний нэгдсэн зохицуулалтыг алдагдуулахад хүргэж байна.

Иймд дээрх үүссэн нөхцөл байдлыг харгалзан 2026-2027 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Ялгаатай байдлаар цалин хөлсийг нэмэгдүүлсэн салбарууд болон цалин хөлсийг огт нэмэгдүүлээгүй бусад төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 2025 оны суурь түвшинтэй харьцуулахад 50 хувиар нэмэгдсэн байхаар тооцож 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэн тогтоож, адил албан тушаалд ижил цалин хөлс олгох;

- 2026 онд цалин хөлсийг нэмэгдүүлээгүй төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг 2027 оны эхний улиралд багтаан 20 хувиар нэмэгдүүлэн тогтоож, 2026 онд 50 хувиар цалин хөлс нь нэмэгдсэн төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг

инфляцын түвшнээр нэмэгдүүлж, салбар болон төрийн албаны ангилал хоорондын цалин хөлсний хэт зөрүүтэй байдлыг арилгах арга хэмжээ авах замаар төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх.

2.Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ирсэн. Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор баталсан албан тушаалын цалингийн сүлжээгээр ерөнхий боловсролын сургуулийн багшийн үндсэн цалин 2,226.0 мянган төгрөг, цэцэрлэгийн багшийн үндсэн цалин 2,339.0 мянган төгрөг байна.

Багш, ажиллагчдын хувьд ажилласан жил, мэргэшил, ур чадвараас хамааран төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 1-25 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 20-40 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 10-20 хувиар, ур чадварын нэмэгдлийг 10-25 хувиар, нөхцөлийн нэмэгдлийг 10-30 хувиар, доктор, профессорын нэмэгдлийг 10-20 хувиар тус тус тооцон авч байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 06 дугаар албан даалгаварт төрийн албан хаагчийн үндсэн цалингийн сүлжээ, нэмэгдэл, нэг удаагийн буцалтгүй тусламж, урамшуулал, тэтгэмж олгох нөхцөл, хугацаа, давтамж, хэмжээг салбар харгалзахгүйгээр төрийн албан хаагчид тэгш, шударга олгох зорилгоор төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг зохицуулсан салбарын хууль тогтоомжийг хүчингүй болгож, Төрийн албаны тухай хуулиар зохицуулахаар хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан. Энэ дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан холбогдох сайд нарт хүргүүлээд байна.

Хуулийн төсөлд төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгаатай холбоотой 30 гаруй хуульд ялгаатай, харилцан адилгүй тусгагдсан заалтуудыг нэг мөр цэгцлэх, давхардлыг арилгах, шалгуур үзүүлэлт, хамрах хүрээг нэг жишигт нийцүүлэх байдлаар одоогийн мөрдөж байгаа хуулийн зохицуулалтыг хэвээр хадгалж, дараах цалин хөлсний асуудлыг шинээр тусган боловсруулаа. Үүнд:

- Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, ажлын ачаалалтай уялдсан нэмэгдэл, урамшууллыг нэмэгдүүлэх, тогтмол нэмэгдлийг хязгаарлах замаар үндсэн цалин, нэмэгдлийн харьцааг оновчтой болгох;
- Төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох зэргээр зарим төрлийн нэмэгдлийг нэгтгэж, үндсэн цалинд шингээх;

- Орон нутгийн нэмэгдлийг нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан алслагдсан бүсийн нэмэгдэл хэлбэрээр сар бүр тогтмол мөнгөн дүнгээр олгох;
- Эрдмийн зэргийн нэмэгдлийг зөвхөн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль тогтоомжоор заасан байгууллагад сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажилладаг эрдмийн зэрэг, цолтой төрийн албан хаагчид олгох.

Мөн яамны зүгээс төрийн албан хаагчдын цалин хөлсний бүтцийг оновчтой болгох, ялангуяа үндсэн цалин, нэмэгдлийн харьцааг зохистой тогтоох, ажлын гүйцэтгэл, ачаалал, үйлчилгээний чанарт суурилсан уян хатан тогтолцоог нэвтрүүлэх боломжит хувилбарыг боловсруулах чиглэлээр Олон Улсын Валютын Сантай хамтран ажиллаж байна.

Т.АУБАКИР

D: 2026 on 10 sar A4